



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/015/НА-СТА-ТТЗ

Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. «cityname»

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 509
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Н.ХАТАНБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн сумын Засаг даргын 154,514.2 мянган төгрөг, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 43,703.4 мянган төгрөг, Засаг даргын тамгын газрын 296,069.4 мянган төгрөг, нийт 494,290.0 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

Засаг дарга нь төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрт орон нутгийн хөгжлийн сан, хоршоо хөгжүүлэх сангийн оны эхний үлдэгдлийг илүү, дутуу төлөвлөсөн, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тайлант онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөвт өртгийг багаар баталсан, хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Засаг даргын тамгын газар нь бараа материалын үлдэгдлийг дутуу тоолж баталгаажуулсан, нөөцийн барааны өвс, тэжээлийг анхан шатны баримтгүй зарлагадсан, Засаг даргын орлогч болон эд хариуцагчийн хувийн харилцах дансанд төсвийн хөрөнгийг шилжүүлэн зарцуулж, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, байгаль орчныг хамгаалах, нөхөн

сэргээх зардлаас янгир нутагшуулах ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, урьдчилгаа төлсөн боловч, гэрээний хугацаанд хэрэгжүүлээгүй, шилэн дансанд мэдээллийг дутуу мэдээлдэг, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлүүд давтан гарсан байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг дутуу байршуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан цагтны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.6.6-д “Төсвийн байгууллага нь төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвхөн бэлэн мөнгөний үйлчилгээ авах зорилгоор ЖМС-г картын дансандаа шилжүүлэн авна.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-д “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.”, 70 дугаар зүйлийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.”, 70.2.2-т “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс”/, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг.”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” гэснийг зөрчиж, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг орон нутгийн төсвийн орлогоос 441,741.7 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэгээс 1,515,954.4 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгээс 533,065.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 32,500.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 669,865.4 мянган төгрөг нийт 3,193,127.2 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр баталжээ.

Төсвийн тодотголоор аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 141,692.5 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 168,861.5 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвийн орлогыг 63,118.3 мянган төгрөгөөр, урьд үлдэгдлийг 49,122.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,994,813.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн авч 2,534,764.8 мянган төгрөгийг зарцуулж, 296,764.8 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Сумын Засаг даргын харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 765,682.4 мянган төгрөгийн 18 алдаа, зөрчил илрүүлснээс 305,022.7 мянган төгрөгийн 6 алдааг санхүүгийн тайланд аудитын явцад залруулж, 405,473.5 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 55,186.2 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 2 албан тушаалтанд хариуцлага тооцох албан албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд нийт 252,341.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 97,827.6 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 16,700.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 137,814.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч ажиллалаа.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 15 дугаар хуралдаанаар Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтийн тайланг “Үр дүн гарсан” гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан****/мянган төгрөгөөр/**

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,133,210.49	1,236,436.4
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	731,315.62	630,692.88
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	218,333.28	315,529.59
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	-	88,425
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	138,581.60	151,388.92
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	44,980.00	50,400.00
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,932,251.83	3,948,017.51
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,932,251.83	3,948,017.51
9	1.2.2.02 Биет хөрөнгө		3,888,157.83	3,903,953.51
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	44,094	44,064
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		5,065,462.32	5,184,453.9
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		239.89	176,672.76
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		239.89	176,672.76
14	2.1.1.03 Өглөг		239.89	176,672.76
15	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		5,065,222.43	5,007,781.15
16	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		5,065,222.43	5,007,781.15
17	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		293,627.26	293,627.26
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		4,632,012.88	4,574,571.59
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		139,582.29	139,582.29
20	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		5,065,462.32	5,184,453.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан
/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		3,144,594.79	2,569,033.13
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		588,834.35	617,767.03
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		300,455.66	330,213.44
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		300,455.66	330,213.44
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		46,075.41	49,813.80
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		242,303.29	237,739.78
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	803,192.17	1,951,266.10
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		-	1,385,720.20
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,752,568.27	-
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,832,103.100	2,356,043.78
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		1,832,103.1	2,356,043.78
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,713,754.08	2,336,888.18
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		720,108.78	923,412.39
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		87,081.25	110,134.51
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		340,731.54	451,146.39
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		55,812.61	57,852.43
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		859.00.00	-
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		103,733.71	48,768.15
19	1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал		23,466.00	27,835.00
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		162,720.25	225,061.18
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		219,240.94	492,678.12
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		118,349.03	19,155.60
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,312,491.69	212,989.35
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		486,988.93	270,306.52
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(486,988.93)	(270,306.52)
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		825,502.75	(57,317.17)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,423,391.99	2,448,869.69
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	588,834.35	617,767.03
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	300,455.66	330,213.44
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	46,075.41	49,813.80
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	242,303.29	237,739.78
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	36,840.62	27,879.64
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	19,610.04	12,749.81
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	185,852.63	197,110.33
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,221.67	1,831,102.67
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	78,221.67	81,178.27
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	1,385,720.20
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	364,204.20
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,756,335.97	-
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,761,821.65	1,983,501.13
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,761,821.65	1,983,501.13
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,641,631.18	1,959,759.81
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	719,893.94	922,166.90
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,901.25	111,287.98
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	340,731.54	451,202.39
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	44,382.11	43,765.18
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	756.00	80.00
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	102,845.45	50,248.04
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	23,466	27,835.00
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	243,274.49	282,677.18
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	79,380.4	70,497.15
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,190.48	23,741.32
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	661,570.34	465,368.56
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	606,180.78	451,691.30
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	606,180.78	451,691.30
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	606,180.78	451,691.30
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(606,180.78)	(451,691.30)
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	114,300.00
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(114,300.00)
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	55,389.56	(100,622.74)
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	675,926.06	731,315.62
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	731,315.62	630,692.88

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,239,719.68		4,239,719.68
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,239,719.68		4,239,719.68
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	825,502.75		825,502.75
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,065,222.43		5,065,222.43
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,065,222.43		5,065,222.43
6	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(124.11)		(124.11)
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,065,098.32		5,065,098.32
8	1.7 Тайлант үеийн үр дүн	(57,317.17)		(57,317.17)
9	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,007,781.15		5,007,781.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,275,826.10	2,436,911.40
2	3.1.01.1.1 Татварын орлого	467,860.00	617,767.03
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	307,800.00	330,213.44
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	307,800.00	330,213.44
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	240,000.00	262,666.03
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	59,300.00	55,671.04
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	7,500.00	9,876.37
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	1,000.00	2,000.00
9	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	50,750.00	49,813.80
10	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	11,000.00	8,403.15
11	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	750.00.00	780.00
12	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	39,000.00	40,630.65
13	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	109,310.00	237,739.78
14	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	20,860.00	27,879.64
15	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	7,500.00	10,422.90
16	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,500.00	2,530.94
17	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	10,860.00	14,925.80
18	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	12,000.00	12,749.81
19	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	12,000.00	12,749.81
20	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	76,450.00	197,110.33
21	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	75,650.00	196,310.33
22	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	800.00.00	800.00
23	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,807,966.10	1,819,144.37
24	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	69,500.00	80,678.27
25	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	37,000.00	48,192.70
26	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	32,500.00	31,835.57
27	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	650.00
28	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,374,261.90	1,374,261.90
29	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	1,374,261.90	1,374,261.90
30	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	364,204.20	364,204.20
31	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	364,204.20	364,204.20
32	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	396,704.20	3,067,179.73
33	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	(223,826.00)	2,608,945.43
34	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,354,701.90	2,061,590.53
35	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	968,461.40	922,166.90
36	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	490,374.60	478,786.40
37	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	350,874.40	342,015.34
38	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	74,970.00	69,356.65
39	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	12,742.40	2,874.71
40	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	39,500.00	29,133.79
41	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,559.10	111,287.98
42	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	87,252.10	75,741.00
43	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	9,569.70	9,023.82
44	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	4,778.40	4,529.91
45	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	4,778.40	4,340.82
46	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	19,180.5	17,652.42
47	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	519,757.90	450,902.39
48	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	91,808.30	75,589.48
49	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	388,675.30	346,796.16
50	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	39,274.30	28,516.75
51	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	65,656.80	41,182.78
52	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	9,059.40	7,108.40
53	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	33,248.40	23,649.02
54	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,230.30	5,181.81
55	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,563.80	96.00
56	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,554.90	5,147.55
57	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	1,807.10	80.00
58	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,807.10	80.00
59	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	88,048.90	74,587.04

60	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	31,105.80	25,117.00
61	3.1.01.2.1.1.6.02 Тавилга	4,000.00	-
62	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943.10	-
63	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	52,000.00	49,470.04
64	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	37,089.00	27,835.00
65	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	37,089.00	27,835.00
66	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	461,541.40	357,651.30
67	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	449,874.50	352,699.56
68	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	961.70	-
69	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	6,014.30	2,879.69
70	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	536.40	514.70
71	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.60	-
72	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,945.40	1,414.80
73	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	963.50	142.56
74	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	86,780.30	75,897.15
75	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	70,339.40	68,683.35
76	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,440.90	7,213.80
77	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-2,578,527.90	547,354.90
78	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-2,598,109.40	532,414.90
79	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	-2,598,109.40	532,414.90
80	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	19,581.50	14,940.00
81	3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,000.00	12,870.00
82	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,581.50	2,070.00
83	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	486,904.20	343,934.30
84	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	486,904.20	343,934.30
85	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	133,626.00	114,300.00
86	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	133,626.00	114,300.00
87	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,879,121.90	(630,268.34)
88	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,879,121.90)	630,268.34
89	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,879,121.90)	630,268.34
90	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	725,005.72
91	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	627,152.28

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Нийт дүн
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,458,298.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,458,298.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,906,979.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	300,000.00
210301	Гэрэл, цахилгаан	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,582,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,582,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,750,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	600,000.00
210604	Урсгал засвар	1,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,274,579.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,274,579.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,151,319.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	5,151,319.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,458,298.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,458,298.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,001,247.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,457,051.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Мөрөн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн 2, улсын төсвийн 4 байгууллага, 1 төрийн сангийн, 3 тусгай сан нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж “Хязгаарлалттай”, хүүхдийн цэцэрлэг, ЕБС, ЭМТ-ийн санхүүгийн тайланд Платиниум прогресс аудит ХХК аудитыг гэрээгээр гүйцэтгэж хүүхдийн цэцэрлэгт “Хязгаарлалттай”, ЕБС, ЭМТ-д “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус өгсөн.

Сумын ИТХ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Соёлын төв аудитын түүвэрт хамрагдсан болно.

3.1 Тус сумын харьяа орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 644,798.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 305,022.7 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 305,195.8 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 34,580.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн аудитын асуудлаар илрэсэн зөрчлийг байгууллагаар харуулбал:

Засаг даргын тамгын газар

1. Бараа материалын тайланг хагас, бүтэн жилээр бөөн дүнгээр гаргасан, орлого, зарлагын анхан шатны баримтын бүрдүүлэлт, тайлан гаргалт, тооцоо бодолтод бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс тодруулгын тайлан, дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдэлээс 5,713.1 мянган төгрөгөөр, тооллогын бүртгэлээс 1,440.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэж, баталгаажуулсан.

2. Засаг даргын орлогч, эд хариуцагчийн хувийн харилцах дансанд наадам, сургалт, тэмцээн уралдааны зардал, шагнал, сэлбэг хэрэгслийн үнэ 16,420.9 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан нь анхан шатны баримтгүй, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлсэн.

3. Бараа материалын тайлангийн нөөцийн бараа данснаас 34.6 сая төгрөгийн өвс, тэжээл, хивгийг анхан шатны баримтгүй зарлагадсан.

Шийдвэрлэлт: Төлбөр барагдуулах 1 акт тогтоосон.

4. Өмнөх оны аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэлийг журам, зааврын дагуу бүртгэж тайлагнадаггүй, худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулдаггүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй хийдэг, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулдаг зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, дахин давтан гаргасан байна.

Шийдвэрлэлт: Байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулахаар 2 албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 120,883.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 100,277.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгч, 20,606.2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоосон байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн аудитын асуудлаар илрэсэн зөрчлийг байгууллагаар харуулбал:

Ерөнхий боловсролын сургууль

1. Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас 3,395.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардалга хүргүүлсэн.

2. Ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 3 ажилтанд 1,699.4 мянган төгрөгийн цалин давхардуулан, нэг ажилтанд 17 хоногийн 2,516.0 мянган төгрөгийн ээлжийн амралтын нөхөн олговор, 2,182.6 мянган төгрөгийн урамшуулал, 3424.0 мянган төгрөгийн цалин нийт 9,821.9 мянган төгрөгийн цалин, урамшууллыг илүү олгосон.

Цэцэрлэг

3. Ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 1 ажилтанд 2,013.0 мянган төгрөгийн цалин, тушаал шийдвэргүй 1,543.4 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, 1,486.4 мянган төгрөгийн ээлжийн амралтын нөхөн олговор, 2,613.1 мянган төгрөгийн цалин нийт 7,655.9 мянган төгрөгийн цалин, урамшуулал, нөхөн олговрыг илүү олгосон.

Эрүүл мэндийн төв

4. Нэг ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 463.4 мянган төгрөгийн цалин давхардуулсан, мөн ажлын чиг үүрэгт хамааралгүй 2 ажилтанд илүү цагийн хөлсийг хавтгайруулан тушаал шийдвэргүй илүү олгосон 2,664.9 мянган төгрөг, нийт 3128.3 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Шийдвэрлэлт: Төлбөр барагдуулах 3 акт тогтоосон.

3.3 Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 252,341.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 97,827.6 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 16,700.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 137,814.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

3.3.1 Албан шаардлага:

1. Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрт орон нутгийн хөгжлийн сангийн эхний үлдэгдлийн 5,700.0 мянган төгрөгийг дутуу төлөвлөж, хоршоо хөгжүүлэх сангийн эхний үлдэгдийг 1,000.0 мянган төгрөгөөр илүү батлуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тайлант онд шинээр хэрэгжүүлэх 35,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Орон нутаг судлах танхим" төсөл, арга хэмжээний эхний жилийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 10,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д "шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.3.4.2-т "шинээр эхлэх барилга байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга

хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.4 Зөвлөмж

1. Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагын үлдэгдэлд 38 зээлдэгчийн 297.0 сая төгрөг байгаагаас 5-аас дээш жилийн насжилттай 34 зээлдэгчийн 137.8 сая төгрөгийн зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны А/361 тоот тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 7.3-т "Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж, зээлийг Сангийн дансанд буцаан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулна." гэснийг зөрчсөн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн 5-аас дээш жилийн насжилттай үлдэгдлийг төлүүлэхээр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагдаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ИТХ	1	931.1			1	931.1	1	931.1				
ЗДТГ	5	584,882.1	1	101,266.9	4	483,615.2	5	584,882.1				
ХХС	1	677.6	1	677.6			1	677.6				
ОНХС	1	76,994.4			1	76,994.4	1	76,994.4				
ОНТБ-ын дүн	8	663,485.2	2	101,944.5	6	561,540.7	8	663,485.2	0	0.00	0	0.00
Соёлын төв	1	19,962.2			1	19,962.2	1	19,962.2				
УТБ-ын дүн	1	19,962.2	0	0.0	1	19,962.2	1	19,962.2	0	0.00	0	0.00
Засаг дарга	1	1,956.8	1	1,956.8			1	1,956.8				
ТТЗ-ийн дүн	1	1,956.8	1	1,956.8	0	0.0	1	1,956.8	0	0.00	0	0.00
Дүн	10	685,404.2	3	103,901.3	7	581,502.9	10	685,404.2	0	0.00	0	0.00

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
ИТХ	1	4,275.6			1	4,275.60							
ЗДТГ	5	34,842.9	2	6,308.2	3	32,810.3							
ОНБ-ын дүн	6	39,118.5	2	6,308.2	4	37,085.9	0	0.0	0	0.0	0	0.0	
ЕБС	1	2,665.1	1	2,665.1									
Цэцэрлэг	1	2,851.1	1	2,851.1									
УТБ-ын дүн	2	5,516.2	2	5,516.2	0	-	0	0.0	0	0.0	0	0.0	
Засаг дарга	4	96,629.2	1	3,804.2	2	25,376.8	1	67,448.2					
ТТЗ-ийн дүн	4	96,629.2	1	3,804.2	2	25,376.8	1	67,448.2	0	0.0	0	0.0	
Дүн	12	141,263.9	5	15,628.6	6	62,462.7	1	67,448.2	0	0.0	0	0.0	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ИТХ	1	46,271.7			1	46,271.7		
ЗДТГ	1	462,458.0			1	462,458.0		
ОНТБ-ын дүн	2	508,729.7	0	-	2	508,729.7	0	-
Соёлын төв	1	113,543.1			1	113,543.1		
УТБ-ын дүн	1	113,543.1	0	-	1	113,543.1	0	-
Дүн	3	622,272.8	0	-	3	622,272.8	0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	1	40,000.0			1	40,000.0		
Дүн	1	40,000.0	0	0	1	40,000.0	0	0
Нийт дүн	4	662,272.8	0	-	4	662,272.8	0	-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 268-А2370448
ХЭА-2026/015/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тайлант онд шинээр хэрэгжүүлэх 35.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Орон нутаг судлах танхим" төсөл, арга хэмжээний эхний жилийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 10.0 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д "шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.3.4.2-т "шинээр эхлэх барилга байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээний төсөвт өртгийг тэнцүү хувааснаас бууруулж төлөвлөдөг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга Н.Хатанбаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 267-А23 70448

ХЭА-2026/015/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрт орон нутгийн хөгжлийн сангийн эхний үлдэгдлийн 5,700,000.00 (таван сая долоон зуун мянга) төгрөгийг дутуу төлөвлөж, хоршоо хөгжүүлэх сангийн эхний үлдэгдлийг 1,000,000.00 (нэг сая) төгрөгөөр илүү батлуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрт урьд оны үлдэгдлийг бүрэн төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга Н.Хатанбаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА